

**“МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ ХОЁР,
ГУРАВ ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа, Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулахаар тогтлоо.


Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Н.ЭНХБОЛД